

## ИНЕГ-ЫН ДОТООД АУДИТЫН 2014 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2014.12.18

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын тасаг нь Зам, тээврийн сайдын 2013 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 68 дугаар тушаалаар батлагдсан ИНЕГ-ын зохион байгуулалтаар бүтцээрээ ИНЕГ-ын даргын шууд удирдлага дор тасгийн дарга, хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн 1, аудитор 3, нийт 5 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байсан ба 2014 оны 8 сараас 1 ажилтан шилжиж 4 орон тоотойгоор ажиллаж байна.

### **Үйл ажиллагаандаа баримтлах эрх зүйн үндсэн баримт бичиг:**

- Төсвийн тухай хууль,
- Дотоод аудитын дүрэм / ЗГ-ын 2012 оны 129 дүгээр тогтоол/
- Дотоод аудитын мэргэжлийн олон улсын стандартууд
- “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний журам”/ЗГ-ын 2013 оны 322 дугаар тогтоол/
- Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын үйл ажиллагааны журам /ИНЕГ-ын А/326 дугаар тушаал/

**Үндсэн зорилго** нь байгууллагын стратеги зорилтыг биелүүлэхэд бие даасан байдалтайгаар эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын системийн үр ашгийг үнэлэх, сайжруулахад бодит баталгаажуулалт болон зөвлөгөөгөөр хангах, байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, үнэ цэнийг нэмэгдүүлэх, бодлого, төсөл, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийн явцын талаарх мэдээлэл цуглуулж, мэдээллээр удирдлага, холбогдох ажилтнуудыг хангаж, хэрэгжилтийг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

### **Дотоод аудитын чиглэлээр:**

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын 2014-2016 он хүртэлх дунд хугацааны төлөвлөгөөг боловсруулан, ИНЕГ-ын даргаар 2014 оны 6 дугаар сарын 19-ний өдөр батлуулсан.

### **2014 онд хийгдсэн төлөвлөгөөт аудит:**

Дотоод аудитын 2014 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, дотоод аудит хийх хуваарийг ИНЕГ-ын даргаар батлуулан, батлагдсан хуваарийн дагуу ИНЕГ-ын дотоод зохион байгуулалтын 9 нэгж алба, харьяа байгууллагад дотоод аудит хийлээ.

№	Шалгалтад хамрагдсан байгууллага	Хугацаа
1.	Санхүү, эдийн засгийн газар Нягтлан бодох бүртгэлийн хэлтэс,	2014.01.01-2014.04.25
2.	Хөрөнгө оруулалт, захиалагчийн алба	2014.01.01-2014.03.18
3.	“Чингис хаан” Олон улсын буудал, Газрын үйлчилгээний алба, Нисэхийн мэдээллийн үйлчилгээний алба, Шалгалтын нислэг зураглалын албаны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй	2014.03.21-2014.04.04
4.	Нисэхийн сургалтын төвийн үйл ажиллагаа	2014.03.20-2014.04.04
5.	Нисэхийн мэдээллийн үйлчилгээний албаны үйл ажиллагаа	2014.05.05 – 2014.05.26

6.	Газрын үйлчилгээний албаны үйл ажиллагаа	2014.05.29-2014.07.28
7.	Техник хангалт, үйлчилгээний албаны үйл ажиллагаа	2014.09.19 – 2014.10.17
8.	Сэргээн засал сувиллын цогцолборын үйл ажиллагаа	2014.10.28 – 2014.11.07
9.	Агаарын хөдөлгөөний үйлчилгээний албаны үйл ажиллагаа	2014.11.01 – 2014.11.26

**Төлөвлөгөөт бус аудит:**

№	Шалгалтад хамрагдсан үйл ажиллагаа	Хугацаа
1.	ГҮА-ны ажилчдын удаан жилийн нэмэгдэл олголтод гэнэтийн шалгалт хийх	2014.01.29-2014.02.08
2.	НЭСЗСЦ, НМУА, ШНЗА-ны ажилчдын удаан жилийн нэмэгдэл олголтод аудит хийх	2014.02.02-2014.02.15
3.	“Чингис хаан” ОУНБ-д ажилчдын удаан жилийн нэмэгдэл олголтод аудит хийх	2014.02.01-2014.02.20
4.	ИНЕГ, Герман улсын Prisma групптэй хийсэн гэрээнд аудит хийх	2014.04.25-2014.04.28
5.	ГҮА-ны кассын үйл ажиллагаанд гэнэтийн шалгалт хийх	2014.05.29-2014.06.02
6.	Сэргээн засал сувиллын цогцолборт мэдээллийн дагуу хяналт шалгалт	2014.06.16-2014.06.18
7.	ИНЕГ-ын гадаад арга хэмжээ, сургалтын явцын талаар аудит хийх	2014.11.01-2014.11.30
8.	ЗТЯ-ны ТЗУГ-аас ирсэн 2014.09.03-ны 5/5106 тоотын дагуу хийх аудит	2014.11.01-2014.11.30
9.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж явуулсан хөрөнгө оруулалт, бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажлын явц /2014 он/	2014.11.01-2014.11.30
10.	“Чингис хаан” Олон улсын буудалд СЯ, ЗТЯ, ИНЕГ-ын хамтарсан эрсдлийн аудит	2014.11.01 - 2014.12.05
11.	Хувь хүмүүстэй холбогдох цалин хөлсний болон ээлжийн амралтын тооцоонд хийсэн аудит	2014.11.12-2014.11.13

Байгууллагын 2014 оны үйл ажиллагаанд хууль тогтоомжийн хэрэгжилт, эрх зүйн акт, баримтуудыг хэрхэн дагаж мөрдөж байгааг хянах гүйцэтгэлийн аудитыг голчлон хийлээ. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилт
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтын хэрэгжилт
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт
- Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартуудын хэрэгжилт
- Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын хэрэгжилт
- Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын хэрэгжилт
- Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 34 дүээр тогтоол батлагдсан Ажлын байрны тодорхойлолт боловсруулах зааврын хэрэгжилт
- Төрийн албан хаагчийн хувийн хэргийн хэрэг хөтлөх журам
- Томилолтын зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай Сангийн сайдын 2011 оны 132 дугаар тушаалын хэрэгжилт
- Хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилт

## 2014 онд илрүүлсэн зөрчил, дутагдал түүний барагдуулалтын байдал

2014 онд нийт 150 зөвлөмжийг харьяа алба, нэгжүүдэд хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

№	Байгууллагын нэр	Өгсөн зөвлөмж
1.	Санхүү, эдийн засгийн газар, Нягтлан бодох бүртгэлийн хэлтэс	33
2.	Хөрөнгө оруулалтын хэлтэс	27
3.	“Чингис хаан” Олон улсын буудал, Газрын үйлчилгээний алба, Нисэхийн мэдээллийн үйлчилгээний алба, Шалгалтын нислэг зураглалын албаны хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуй	22
4.	Нисэхийн сургалтын төв	14
5.	Нисэхийн мэдээллийн үйлчилгээний алба	15
6.	Газрын үйлчилгээний алба	12
7.	Техник хангалт, үйлчилгээний алба	12
8.	Сэргээн засал сувиллын цогцолбор	2
9.	Агаарын хөдөлгөөний үйлчилгээний алба	0
10.	ИНЕГ-ын 2014 оны гадаад арга хэмжээний гүйцэтгэлийн байдалд хийсэн аудит	9
11.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж явуулсан хөрөнгө оруулалт, бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажлын явц /2014 он/	2
12.	Хувь хүмүүстэй холбогдох цалин хөлсний болон ээлжийн амралтын тооцоонд хийсэн аудит	2
13.	Чингис хаан” олон улсын буудалд СЯ, ЗТЯ, ИНЕГ-ын хамтарсан гүйцэтгэлийн аудит	0
<b>Нийт</b>		<b>150</b>

Дотоод аудитын явцад илэрч байгаа зөрчил дутагдлыг зөрчлийн төрлөөр гаргавал доорхи байдалтай байна.

№	Зөрчлийн төрөл	Нийт зөрчлийн дүнд эзлэх хувь
1	Улсын төсөвт илүү төлсөн татвар	22,1
2	Дутуу төвлөрүүлсэн орлого	18,1
3	Журам зөрчсөн тэтгэмж, тусламж	43,6
4	Илүү олгосон томилолтын зардал	0,50
5	Үндсэн баримтгүй зарлага	0,40
6	Зориулалт бусаар зарцуулсан хөрөнгө	3,00
7	Буруу олгогдсон удаан жилийн нэмэгдэл	0,40
8	Хөдөлмөрийн нөхцлийн давхардсан нэмэгдэл	9,20
9	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	2,70
	Бүгд	100,0

### **3.Бусад ажил**

Байгууллагын санхүүгийн, үйл ажиллагааны, стратегийн, нийцлийн эрсдлүүдийг тодорхойлж, 3 жилийн төлөвлөгөөг боловсруулан, эрсдэлтэй үйл ажиллагаанд аудит хийх аргачлалтай боллоо.

“Чингис хаан” олон улсын нисэх буудалд СЯ, ЗТЯ, ИНЕГ-ын хамтарсан гүйцэтгэлийн аудитыг Агаарын тээврийг хялбаршуулах үндэсний хөтөлбөр, Хилийн боомтын тухай хууль, Чингис хаан” олон улсын буудлын үйл ажиллагааны хэрэгжилтэнд эрсдлийн үнэлгээ хийж, зөвлөмжөөр хангаж ажиллав.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газартай хамтран ажиллах гэрээг цаашид үргэлжлүүлэхээр 2014 оны 04 дүгээр сарын 18-нд хамтран ажиллах гэрээг байгуулсан ба гэрээны эрх үүргийн дагуу хагас бүтэн жилийн тайлан хүргүүлэн ажиллаж байна.

### **ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ТАСАГ**